

БАТЛАВ
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ П.НЯМДАВАА
2026 оны 03 сарын 11 ны өдөр
ХТҮ7862 9424070659 6233722

**ТӨРИЙН ӨМЧИЙН ЭД ХӨРӨНГИЙН ТҮРЭЭСЛЭГЧИЙГ СОНГОХ
“СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН БАРИМТ БИЧИГ”**

**1. Төрийн болон орон нутгийн өөрийн өмчийг
түрээслэгчийг сонгон шалгаруулах зар**

Улсын бүртгэлийн ерөнхий газар өөрийн өмчийн Цайны газрыг түрээслэх хуулийн этгээд, иргэнийг сонгон шалгаруулах зарыг байгууллагын www.burtgel.gov.mn албан ёсны цахим хуудсанд нийтэлнэ.

Түрээслэх эд хөрөнгийн танилцуулга:

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг 11-р хороо, Цагдаагийн гудамж 20 Б УБЕГ-ын “Архив үйлчилгээний цогцолбор төв”-ийн В блок хэсгийн 3 давхарт байрлах 50м2 талбайтай 50 хүний суудалтай, нийтийн хоолны үйлдвэрлэл явуулах зориулалттай цайны газар. Цайны газар нь Төрийн онцгой объект тул зөвхөн УБЕГ-ын албан хаагчид орно.(Өдөрт 20-40) хүн үйлчлүүлдэг.

Сонгон шалгаруулалтын ерөнхий мэдээлэл

д/д	Сонгон шалгаруулалтын мэдээлэл хүлээн авах эцсийн хугацаа	2026 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн 10:00 цагт
1.	Материал хүлээн авах хаяг	Улаанбаатар хот Сүхбаатар дүүрэг 11-р хороо Цагдаагийн гудамж 20Б УБЕГ-ын төв байр сонгон шалгаруулалт явуулах ажлын хэсгийн нарийн бичиг П.Батбилэгт хүлээлгэн өгнө
2.	Материал нээх хугацаа, хаяг байршил	Улаанбаатар хот Сүхбаатар дүүрэг 11-р хороо Цагдаагийн гудамж 20Б УБЕГ-ын төв байр 302 тоот өрөөнд 2026 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн 10 :30 цагт нээнэ.
3.	Материал ирүүлэх, хүлээн авах	- Оролцогч сонгон шалгаруулалтын материалыг тогтоосон хугацаанд бүрэн бүрдүүлж битүүмжлэн ирүүлнэ. - Бүрдүүлсэн материалын жагсаалтыг дугуйны гадна талд бичсэн байна. - Оролцогч нь зард заасан хугацаанд материалаа өөрийн биеэр эсхүл итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр дамжуулан түрээслэгчдийн ажлын хэсгийн нарийн бичигт хүлээлгэн өгнө.
4.	Эд хөрөнгийн түрээслүүлэх үнийн доод хэмжээ	500,000 (Таван зуун мянга) төгрөг

5.	Оролцогчдын бүрдүүлж ирүүлэх материал	1. Түрээслэх албан хүсэлт, үнийн санал, УБЕГ-ын тавьсан нөхцлийг хүлээн эзвшөөрсөн албан бичиг ирүүлэх 2. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар хувь 3. Үйл ажиллагааны мэргэжлийн байгууллагад бүртгүүлсэн талаарх бичиг баримт 4. Санхүүгийн чадварыг нотлох хөрөнгийн жагсаалт, дансны хуулга,(захиралынх байж болно) үйл ажиллагаа эхлүүлэхэд шаардлагатай эх үүсвэр нотлох баримт 5. Үйл ажиллагааны танилцуулга, ажлын туршлагын талаарх мэдээлэл (6. Ажиллах хүчний мэдээлэл, мэргэжлийн диплом үнэмлэхний хуулбар 7. Оролцогч нь ирж ажлын байртай танилцан нэмэлтээр үаардлагатай тоног төхөөрөмжийг тодруулах боломжтой
6.	Хүний нөөцөд тавигдах шаардлага	1. Ахлах тогооч-1 -Нийтийн хоол үйлдвэрлэлийн мэргэжилтэй, мэргэжлээрээ 2 ба түүнээс дээш ажилласан туршлагатай байх 2. Туслах тогооч -1 -Нийтийн хоол үйлдвэрлэлийн мэргэжилтэй, мэргэжлээрээ 2 ба түүнээс дээш ажилласан туршлагатай байх 3. Угаагч-Үйлчлэгч-1 4. Ажилтнуудын эрүүл мэндийн урьдчилсан сэргийлэх үзлэгт хамрагдсан материалын хуулбар
7.	Бусад	1. Хоолны цэсийг боловсруулахдаа УБЕГ-ын албан хаагчдын саналыг авч,цэ гаргах боломжтой байх (хоолонд амтлагч хийхгүй, цагаан хоол болон эмчилгээний 1-3 төрөл байх г.м) 2. Шим тэжээл зохистой хооллолтын сургалтанд хамрагдсан, өмнө нь эмчилгээний хоолны чиглэлээр ажиллаж байсан бол давуу тал болно. 3. Хоолны нэр, төрөл бүрийн үнийн дээд, хязгаарын санал